

**Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн
хүлээгдлийн мэдээний нэгтгэл**

/2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар/

1. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн амбулаторийн тусламж үйлчилгээ өмнөх саруудтай харьцуулахад хүлээгдэл багатай, нийт 21 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн хүлээгдэлтэй байгаа нь өмнөх сараас 3 дахин буурсан байна.

Оношилгооны чиглэлээр тусламж, үйлчилгээний хүлээгдэл их байна. Нийт 735 үйлчлүүлэгч багажийн оношилгоо хийлгэхээр 3-с дээш хоног хүлээж байна. /Хүснэгт 1/.

**Хүснэгт 1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн багажийн шинжилгээний
хүлээгдэл**

№	Оношилгооны нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног	
1	MRI	30	50	510	590
2	КТ	40	40	-	80
3	Ходоодны дуран	-	40	-	40
4	Урологийн оношилгооны дуран	-	24	-	24
5	Зүрний эхо	1	-	-	1
	НИЙТ	71	154	510	735

Хамгийн их хүлээгдэлтэй оношилгоонд MRI шинжилгээ хамаарч байгаа бөгөөд, нийт хүлээгдэж буй 590 үйлчлүүлэгчийн дийлэнх буюу 86% /510/ нь 15-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна. КТ хийлгэхээр 80, ходоод дурандуулахаар 40 үйлчлүүлэгч тус тус 3-с дээш хоног хүлээж байна.

Харин хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хувьд маш их хүлээгдэлтэй, нийт 1680 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь өмнөх сартай ойролцоо үзүүлэлттэй байна. /Хүснэгт 2/.

**Хүснэгт 2. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж,
үйлчилгээний хүлээгдэл**

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Нүдний тасаг	3-6 хоног	52
		7-14 хоног	73
		15-30 хоног	185
		1 сараас дээш	425
	НИЙТ		735
2	Чих, хамар, хоолойн тасаг	3-6 хоног	15
		7-14 хоног	42
		15-30 хоног	64
		1 сараас дээш	423

	Нийт		544
3	Урологийн тасаг	3-6 хоног	25
		7-14 хоног	35
		15-30 хоног	50
		1 сараас дээш	50
	Нийт		160
4	БШГМЗ тасаг	3-6 хоног	2
		7-14 хоног	13
		15-30 хоног	21
		1 сараас дээш	61
	Нийт		97
5	Мэс заслын тасаг	3-6 хоног	39
		7-14хоног	40
		15-30 хоног	-
		1 сараас дээш	-
	Нийт		79
6	Цусны эмгэг судлал	3-6 хоног	9
		7-14хоног	4
		15-30 хоног	7
		1 сараас дээш	1
	Нийт		21
7	Зүрх судасны эмгэг судлал	3-6 хоног	-
		7-14 хоног	2
		15-30 хоног	3
		1 сараас дээш	14
	Нийт		19
8	Хоол боловсруулах эрхтний эмгэг судлал	3-6 хоног	3
		7-14хоног	2
		15-30 хоног	5
		1 сараас дээш	3
	Нийт		13
9	Дотоод шүүрэл судлал	3-6 хоног	1
		7-14хоног	2
		15-30 хоног	3
		1 сараас дээш	-
	Нийт		6
10	Бөөр судлал	3-6 хоног	2
		7-14хоног	3
		15-30 хоног	-
		1 сараас дээш	-
	Нийт		5
11	Хэрх үе судлал	15-30 хоног	1
	Нийт		1
	БҮГД	3-6 хоног	148
		7-14хоног	216
		15-30 хоног	339
		1 сараас дээш	977
	НИЙТ		1680

Нүдний тасагт хэвтэхээр нийт 735 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь эмнэлгийн хэмжээнд нийт орны хүлээгдлийн 43% -ийг эзэлж байгаа ба 425 үйлчлүүлэгч 1 сар

ба түүнээс дээш хугацаагаар хүлээгдэлтэй байна. Нүдний хиймэл болорын нөөц дуссантай холбоотой болор солиулахаар хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо ийнхүү өмнөх сарын адилаар ихээр нэмэгдсэн байна.

Мөн Чих хамар хоолойн тасагт хэвтэж эмчлүүлэхээр 544 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн дийлэнх буюу 78% /423/ нь 1 сараас дээш хоногоор ор хүлээж байна.

2. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өмнөх сартай ижил түвшинд байна. Нийт 134 үйлчлүүлэгч амбулаторийн 8 чиглэлийн кабинетийн эмчид үзүүлэхээр 2-с дээш хоног хүлээж байна. Хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж, үйлчилгээнд Хоол боловсруулах эрхтэн судлал, Мэс засал судлал, Мэдрэл судлалын эмчийн үзлэг орж байна./Хүснэгт 3/.

Хүснэгт 3. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	-	2	35	37
2	Мэс засал судлал	3	-	28	31
3	Мэдрэл судлал	3	-	20	23
4	Нүд судлал	-	-	18	18
5	Бөөр судлал	1	3	13	17
6	Урологи	1	-	2	3
7	Эмэгтэйчүүд судлал	1	-	2	3
8	Зүрхний эмгэг судлал	-	-	2	2
	НИЙТ	9	5	120	134

Амбулаторийн эмчийн үзлэг хийлгэхээр 134 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаагийн дийлэнх буюу 90% нь 7-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 78 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлттэй ойролцоо түвшинд байна. Зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 34, Хэвлийн эхо-д харуулахаар 26, Рентген оношилгоо хийлгэхээр 6, MRI оношилгоо хийлгэхээр 12 үйлчлүүлэгч тус тус хүлээж байна. Шинжилгээ өгөхөөр нийт 53 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа ба хамгийн олон буюу 44 үйлчлүүлэгч биохимийн шинжилгээ өгөхөөр хүлээж байна.

Тус эмнэлэг орны хүлээгдэл маш ихтэй байна. Хэвтэж эмчлүүлэхээр нийт 507 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас 123 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Чих хамар хоолойн тасаг хамгийн их хүлээгдэлтэй, уг тасагт хэвтэн эмчлүүлэхээр 159 үйлчлүүлэгч ор хүлээж байна /Хүснэгт 4/.

Хүснэгт 4. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа	Бүгд
---	-------------	---------------------	------

		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Чих, хамар, хоолой судлал	17	18	41	83	159
2	Хоол боловсруулах эрхтэн судлал	20	41	37	15	113
3	Эмэгтэйчүүдийн эмгэг судлал	27	42	12	-	81
4	Зүрх судасны эмгэг судлал	17	18	21	-	56
5	Уламжлалт эмчилгээ	9	21	15	-	45
6	Мэс засал судлал	11	18	12	-	41
7	Урологи	2	6	-	-	8
8	Бөөрний эмгэг судлал	4	-	-	-	4
	НИЙТ	107	164	138	98	507

Мөн Хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт хэвтэхээр 113, Эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасагт хэвтэхээр 81 үйлчлүүлэгч тус тус 3-с дээш хоног хүлээж байна.

3. Улсын Улсын гуравдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж үйлчилгээ хүлээгдэл ихтэй байна. Нийт 500 үйлчлүүлэгч амбулаторид үзүүлэхээр 2-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас 56 үйлчлүүлэгчээр буурсан үзүүлэлттэй байна. /Хүснэгт 5/

Хүснэгт 5. Улсын гуравдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо			Нийт
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Мэдрэл судлал	6	4	85	95
2	Зүрх судас судлал	4	2	75	81
3	Хоол боловсруулах эрхтэн судлал	4	9	67	80
4	Бөөр судлал	1	6	48	55
5	Булчирхай судлал	3	5	41	49
6	Нүд	-	-	30	30
7	Мэдрэлийн мэс засал	-	-	25	25
8	Урологи	3	-	21	24
9	Чих хамар хоолой	-	-	21	21
10	Уушиг судлал	2	9	4	15
11	Зүрхний мэс засал	4	4	5	13
12	Мэс засал	3	2	2	7
13	Сэргээн засах	1	2	-	3
14	Уламжлалт эмчилгээ	1	-	1	2
	НИЙТ	32	43	425	500

Мэдрэлийн эмчид үзүүлэхээр 95, зүрхний эмчид үзүүлэхээр 81, Хоол боловсруулах эрхтний эмгэг судлалын эмчийн үзлэгт орохоор 80, Бөөрний эмчид үзүүлэхээр 55 үйлчлүүлэгч 2-с дээш хоног тус тус хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй үзлэгт хамаарч байна. Амбулаторийн хүлээгдлийн дийлэнх буюу 85%

нь 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Хэвлийн эход харуулахаар 81 үйлчлүүлэгч, зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 28, зүрхний эхо-д харуулахаар 51 үйлчлүүлэгч, дурангийн оношилгоо хийлгэхээр 10, Тархины цахилгаан бичлэг хийлгэхээр 16, рентгенд харуулахаар 6, нийт 192 үйлчлүүлэгч хүлээгдэлтэй байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс даруй 40 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа нь хэвлийн эход харуулах хүн ихэссэнтэй холбоотой байна.

2023 оны 5 сард тус эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээ нь өмнөх саруудаас хүлээгдэл харьцангуй багатай, нийт 63 үйлчлүүлэгч шинжилгээ өгөхөөр 2-с дээш хоног хүлээж байна. байна. /Хүснэгт 6/.

Хүснэгт 6. Улсын гуравдугаар төв эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Шинжилгээний нэр	Хүлээгдлийн хугацаа	
		3-6 хоног	7-14 хоног
1	Биохимийн шинжилгээ	27	22
2	Бактерлогийн шинжилгээ	10	-
3	Иммунологи	4	-
	НИЙТ	41	22

Тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ өмнөх сараас харьцангуй хүлээгдэл багатай, нийт 108 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь өмнөх сараас 2 дахин буурчээ. Чих хамар хоолойн тасагт хэвтэн эмчлүүлэхээр 85 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тасагт хамаарч байна. /Хүснэгт 7/

Хүснэгт 7. ШУГТЭ-ийн хамгийн их орны хүлээгдэлтэй 3 тасгийн мэдээ

№	Тасгийн нэр	Хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа хоногийн тоо	Ор буй хүлээж үйлчлүүлэгчийн тоо
1	Зүрх судасны тасаг	3-6 хоног	-
		7-14хоног	-
		15-30 хоног	23
		1 сараас дээш	-
		Нийт	23
2	Мэс заслын тасаг	3-6 хоног	-
		7-14хоног	17
		15-30 хоног	3
		1 сараас дээш	-
		Нийт	20
3	Нүдний тасаг	3-6 хоног	10
		7-14хоног	6
		15-30 хоног	2
		1 сараас дээш	-
		Нийт	18

Зүрх судасны тасагт хэвтэхээр 23, мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 20, Нүдний тасагт хэвтэхээр 18 үйлчлүүлэгч тус тус 3-с дээш хоногоор ор хүлээж байна.

4. Сэтгэцийн эрүүл мэндийн үндсэний төв

Тус төвийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өмнөх сартай ойролцоо үзүүлэлттэй байна. Эмгэг сэтгэл судлалын үзлэгт хамрагдахаар 72 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна. Харин стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 78 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь 4 сарын үзүүлэлттэй харьцуулахад 26 үйлчлүүлэгчээр буурсан байна. 12 үйлчлүүлэгч 3-6 хоног, 19 үйлчлүүлэгч 7-14 хоног, 47 үйлчлүүлэгч 15-30 хоног тус тус ор хүлээж байна. Оношилгоо болон лабораторийн тусламж үйлчилгээ хүлээгдэлгүй байна.

5. Арьсны өвчин судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулатори болон лабораторийн тусламж, үйлчилгээ нь өмнөх сарын адилаар хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин Арьс харшлын тасагт хэвтэхээр 128 үйлчлүүлэгч 3-6 хоног, 80 үйлчлүүлэгч 7-14 хоног, 48 үйлчлүүлэгч 15-30 хоног, нийт 256 үйлчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа нь тус эмнэлгийн хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна.